

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2015 оны 8 дугаар тогтоолын
хавсралт

ХӨНДӨГДСӨН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙХЭД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Сүүлийн жилүүдэд гар аргаар ашигт малтмал олборлогчид туршлагажиж, ашиглаж буй техник технологи сайжирснаар газрыг их хэмжээгээр эвдэн сүйтгэж, байгалийн унаган төрхийг алдагдуулж байна. Хөндөгдсөн газрын тооллогоор гар аргаар ашигт малтмал олборлолт болон зам барилга байгууламжийн элс хайрга олборлолт, уул уурхайн нөлөөллөөс зарим сумдын нутагт их хэмжээний газар эвдэгдсэн мөн байгалийн давагдашгүй хүчин зүйл, ашигт малтмалын бус хүний буруутай үйл ажиллагаанаас болж эвдэрч, сүйдсэн газрын тоо жилээс жилд өссөөр байна.

Иймд аймгийн газар нутагт байгаа эвдэрч, сүйдэж, төлөв байдлаа алдсан талбайд нөхөн сэргээлт хийж байгалийн унаган төрхөнд оруулах ажлыг зохицуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих шаардлага гарч байна.

Хоёр. Журмын зорилго

Хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас эвдэгдэн орхигдсон талбай, байгалийн давагдашгүй хүчин зүйл, ашигт малтмалын бус хүний буруутай үйл ажиллагаанаас болж гэмтсэн газар техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллага сонгон шалгаруулах эсвэл нөхөн сэргээлт хийх ажлын туршлагатай, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан нөхөн сэргээлт хийх үйл ажиллагаанд нь хяналт тавих, нөхөн сэргээсэн талбайг хүлээн авахад энэхүү журмын зорилго оршино.

Гурав. Нөхөн сэргээлт хийх шаардлагатай газар, санхүүжилт, хэмжээг тогтоох үнэлэх

3.1. Байгалийн давагдашгүй хүчин зүйл, ашигт малтмалын бус хүний буруутай үйл ажиллагаанаас болж гэмтсэн газар, хууль бусаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явагдан хариуцах эзэн холбогдогч нь тодорхойгүй болсон талбай зэрэг унаган төрх, байдлаа алдсан газрыг Байгаль орчны багц хуульд нийцүүлэн нөхөн сэргээнэ.

3.2. Нөхөн сэргээх хөрөнгийн эх үүсвэр нь Улсын төсөв, Орон нутгийн төсөв, Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр, хандив тусламжаар санхүүжихийн зэрэгцээ тухайн газар дээрх хаягдал, шлам, отволи, овоолгыг дахин угаах замаар нөхөн сэргээлтийн ажлаа санхүүжүүлж болно.

3.3. Мэргэжлийн байгууллагуудаар нөхөн сэргээлтийн дараа бий болох байгаль орчны төрхийн зураглалыг гаргуулах, нөхөн сэргээх техник, технологийг сонгон, хэрэгжүүлэх үе шат, хугацааг нарийвчилан төлөвлөж, холбогдох зардлыг тооцоолно.

3.4. Тухайн нутгийн иргэдийн санал, эрх бүхий байгууллагын тогтоосон дүгнэлтэнд үндэслэн Аймгийн хэмжээнд нөхөн сэргээх шаардлагатай талбайг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан аймгийн ИТХ-ын хуралдаанаар батлуулна.

3.5. Нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5917:2008, Монгол Улсын стандартуудын шаардлагад нийцүүлэн үнэлж дүгнэнэ.

Дөрөв. Нөхөн сэргээлт хийх аж ахуйн нэгжид тавих шаардлага

4.1. Нөхөн сэргээлт хийх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байна.

4.2. Нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг явуулах шаардлагатай ажиллах хүч, техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

4.3. Татвар, нийгмийн даатгал, банкны хугацаа хэтэрсэн өргүй байна.

4.4. Нөхөн сэргээлт хийх субъект нь хуулийн этгээд байна.

Тав. Сонгон шалгаруулалт

5.1. Сонгон шалгаруулалах гэрээ байгуулах ажлыг тухайн сумын Засаг дарга зохион байгуулж, ИТХ хяналт тавина.

Зургаа. Зар мэдээ

6.1. Сонгон шалгаруулалтын зар мэдээг тухайн захиалагч ажлын 14-өөс доошгүй хоног орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд, ил тод зарлана.

6.2. Зар мэдээнд хөндөгдсөн газрын талбайн хэмжээ, техникийн нөхцөл, тодорхойлолт сонгон шалгаруулалтанд оролцох аж ахуйн нэгж, нөхөрлөлд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага бусад холбогдох мэдээллийг оруулна.

6.3. Зар мэдээнд мэдээллийн лавлах утас, хаягийг тодорхой тусгана.

Долоо. Сонгон шалгаруулалтад оролцогчийн бүрдүүлэх материал

7.1. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн албан ёсны хүсэлт.

7.2. Аж ахуйн нэгжийн танилцуулга /бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, ажиллах хүчний бүтэц, бүрэлдэхүүн, байгууллагын хаяг, утасны дугаар зэргийг дэлгэрэнгүй тусгана/, холбогдох бусад бичиг баримт.

7.3. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар

7.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө/техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг төслөөр ирүүлнэ/. Төлөвлөгөөнд дараах зүйлүүд тусгагдсан байна. Үүнд:

7.4.1.Нөхөн сэргээлтийн ажлыг эхлэн, дуусгах үе шатны календарчилсан төлөвлөгөө

7.4.2.Нөхөн сэргээлтэнд ашиглах техник хэрэгслийн жагсаалт /техникийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түрээсийн гэрээ/

7.4.3. Ажиллах хүчний мэдээлэл

7.4.4. Технологийн болон биологийн нөхөн сэргээлтэд шаардагдах зардлын хэмжээг тооцож гаргасан байна.

7.5. Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан бусад шаардлагыг хангасан байна.

Найм. Төсөл ирүүлэх, шалгаруулах

8.1. Оролцогч тодорхой нэгж талбайг сонгож, талбай дээр хийх ажлынхаа төсөл төлөвлөгөөг сонгон шалгаруулалт зарласан байгууллагад ирүүлнэ.

8.2. Сонгон шалгаруулалт нь төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 7 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

8.3. Захиалагч төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас хоцорч ирүүлсэн аливаа төслийг “хугацаа хоцорсон” гэж үзэж буцаана.

8.4. Тухайн сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг төслийг сонгон шалгаруулна.

8.5. Төслийг хянан үзэх, тодруулах, үнэлэх, харьцуулах болон гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжтэй холбогдсон мэдээллийг тухайн төсөл шалгаруулалтын үйл ажиллагаатай албан ёсоор холбогдолгүй хүнд задруулахыг хориглоно.

8.6. Захиалагч нь сонгон шалгаруулалтын бичиг баримтын шаардлагад үл нийцсэн гэж тогтоогдсон төслөөс татгалзаж оролцогчид ажлын 3 хоногт багтаан албан бичгээр мэдэгдэнэ.

8.7. Захиалагч “шаардалагад нийцсэн” төсөл ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.

8.8. Захиалагч нь талуудын хооронд тохирсон бүх нөхцлүүдийг тусгасан гэрээний маягтыг гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан оролцогчид илгээнэ.

Ес. Гэрээ байгуулах

9.1. Шалгарсан аж ахуйн нэгж эсвэл шууд гэрээлэгч нь гэрээг ажлын 5 хоногт багтаан сумын Засаг даргатай байгуулна.

9.2. Гэрээний бусад оролцогч талууд нь Аймгийн БО, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, бусад мэргэжлийн байгууллагууд, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалалгч нар байна.

9.3. Шалгарсан аж ахуйн нэгж эсвэл шууд гэрээлэгч болон сум орон нутгийн эрх үүргийг гэрээнд зааж өгнө.

9.4. Сумын ЗДТГ нь тухайн нөхөн сэргээх талбайн эвдрэл, чанар байдлаас хамаарч нөхөн сэргээлт хийж буй аж ахуйн нэгжээс барьцаа тавих хөрөнгийн хэмжээг тогтооно. Энэ хэмжээ нь **5.0 сая төгрөгнөөс доошгүй байх бөгөөд** барьцаа хөрөнгийг гэрээнд заасан тусгай дансанд урьдчилж байршуулах ба гэрээний үүргээ биелүүлээгүй бол үл маргах журмаар барьцаа төлбөрөөр гэрээний үүргийг гүйцэтгүүлнэ.

9.5. Гэрээнд заасан хугацаа дуусгавар болсноор гэрээг дүгнэнэ.

9.6. Нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, байршил, хийх хугацаа, эрх үүргийг гэрээнд тодорхой тусгаж өгнө.

Арав. Хяналт шалгалт

10.1. Нөхөн сэргээлтийн төсөлд сонгосон чиглэл, нөхөн сэргээлт хийх шийдэл нь төлөвлөсөн хугацаандаа хэрэгжиж, үр дүнгээ өгөх боломжтой эсэх, орон нутгийн байгаль орчинд аюулгүй, хоргүй, сөрөг нөлөөгүй технологи сонгосон эсэх, нөхөн сэргээлтийн төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд өөр байдлаар хохирол учруулж болзошгүй эсэхэд орон нутгийн байгаль орчны хяналтын байгууллага хяналт тавина.

10.2. Нөхөн сэргээлтийн ажил нь төлөвлөсөн хугацаандаа явагдаж байгаа эсэх, орон нутгийн удирдах байгууллагын саналыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа эсэх, нөхөн сэргээлтийг хэрэгжүүлэх арга зам, технологийн сонголт нь орон нутгийн иргэдийн эрх ашигтай зөрчилдөх эсэх, нөхөн сэргээлттэй холбоотой орон нутгийн иргэдээс санал хүсэлт, өргөдөл гомдол гарч байгаа эсэхэд орон нутгийн төр захиргааны байгууллага хяналт тавина.

10.3. Нөхөн сэргээлтийг хэрэгжүүлэх явцад хийх хяналтын үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн төлөөллийг оролцуулна.

10.4. Нөхөн сэргээлт хийх газрын хил заагийг тухайн сумын Засаг даргын томилсон ажлын хэсэг GPS багажаар хэмжиж, хилийн шав тэмдэг тавьж өгөхдөө тухайн талбай нь аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан эсэхийг нарийвчлан тулган шалгаж, аж ахуйн нэгжид нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулах эрхийг олгоно.

10.5. Гүйцэтгэгч 10.4-т заасан талбайн гадна талд хөрс хуулсан тохиолдолд захиалагч гэрээг цуцлах бөгөөд байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ авна.

Арван нэг. Нөхөн сэргээсэн газрыг хүлээн авах

11.1. Төсөл хэрэгжүүлэгч нөхөн сэргээлтийг дуусгасны дараа хүлээлгэж өгөх хүсэлтээ орон нутгийн засаг захиргааны байгууллагад гаргана.

11.2. Нөхөн сэргээлтийг хүлээн авах комиссыг орон нутгийн засаг захиргааны байгууллагаас томилно.

11.3. Нөхөн сэргээлтийг хүлээн авах комисс нь нөхөн сэргээлтэд тавигдах шаардлага, стандартын хэрэгжилт, нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг үнэлж, дүгнэлт гаргана.

11.4. Хүлээн авах комиссын дүгнэлтийг үндэслэн нөхөн сэргээсэн талбайнуудыг хүлээлцэх акт үйлдэж, түүнд байгууллагуудын төлөөлөл болон төсөл хэрэгжүүлэгчийг төлөөлөх эрх бүхий тушаалтан гарын үсэг зурна.

11.5. Төсөл хэрэгжүүлэгч нөхөн сэргээлтийг хүлээлцэх актанд тусгагдсан мониторинг хийх, арчилгаа тордолгооны болон нэмэлт арга хэмжээний холбогдолтой ажлыг тодорхой хугацаа зааж хариуцна.

11.6. Хүлээлцэх акт үйлдэн хүлээн авсан талбай шинээр эвдэрч байгаль орчинд хохирол учирвал хяналт мониторингийн хугацаанд үүссэн эвдрэлтэй холбоотой нөхөн сэргээлтийг төсөл хэрэгжүүлэгч, хяналт мониторингийн хугацаа дууссанаас хойшхи эвдрэлийн нөхөн сэргээлтийн зардлыг орон нутаг тус тус хариуцна.

-----oO-----